



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 2/16

Жавхлант

**Хагас жилийн тооллогын комисс
томилох тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан "өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам" 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын хагас жилийн эд хөрөнгийг тоолох тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Э.Хонгорзул	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	М.Балдан	Нярав
Гишүүн:	Ж.Хэрлэнцэцэг	Үйлчлэгч
	Х.Энх-Уянга	Дэлгэрхаан багийн Засаг дарга
	Б.Баасанням	Жолооч

2.Хуулинд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нярав (М.Балдан), Нягтлан бодогч (Э.Уранбайгаль) нарт даалгасугай.

3.Хуулинд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг Тооллогын комиссын дарга (Э.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

4.Тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 20-наас 06 дугаар сарын 25-ны өдрүүдэд хийж дуусгаж, Өмч хамгаалах зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Тооллогын комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ШАРАВГАВАА